



Э.Тамир, доктор (Ph.D), профессор
НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн
ахмад багш

УЛС ТӨРИЙН СОЁЛЫН ТОТАЛИТАР ЗАГВАР: ОНОЛ БА ҮЗЭЛ

Abstract: This paper intends to discuss about how totalitarianism had been perceived and understood in the different ways. It argues that totalitarianism is a political system where the state recognizes no limits to its authority and strives to regulate every aspect of public and private life wherever feasible. Totalitarianism is, in fact, not only an independent form of political culture of a society but also a theoretical conceptual model. Ideological totalitarian political philosophy and thinking of people create negative outputs in a society. When the totalitarian value of a government and society dominates in the political culture, the fascist method changes and “brainwashes” people into thinking that a distinctive feature of totalitarian governments is an “elaborate ideology, a set of ideas that gives meaning and direction to the whole society. Totalitarian political culture is, indeed, a conscious biased and idealized reflection of a social reality. On the other hand, the term “totalitarianism” to refer to the structure and goals of the new state, which was described a society in which the ideology of the state had influence, if not power, over most of its citizens. This system politicizes everything spiritual and human: “Everything within the state, nothing outside the state, nothing against the state.”

Түлхүүр үг: тоталитаризм, авторитаризм, фашизм, социализм, нацизм, вождизм, большевизм, манкуритизм,

Авторитарист ба тоталитарист хандлага нь мөн чанартаа улс төрийн соёлын бие даасан хэв маяг төдийгүй өөр хоорондоо өвөрмөц ялгаа бүхий төрөл жаягтай ойлголтууд юм.

Тоталитаризм нь нийгмийн бүхий л хүрээг төр хэмээх ойлголтод захируулж үйлчилдэг бол авторитаризм нь үзэл суртал ба шашны итгэл үнэмшилд үйлчилж эдийн засаг, нийгэм, оюуны болон социаль хүрээний бүхий л асуудлыг оршин буй нийгмийн тогтолцоог хадгалж үлдэх ашиг сонирхолд нийцүүлж

үйлчилсэн улс төрийн өвөрмөц дэглэм төдийгүй оршин буй нийгэм, ангийн засаглалын бүтэц, хэлбэршил, гэр бүлийн ба хувь хүний харилцааны энгийн хэлбэрүүдийг өөрчлөхгүй ч тухайн үндэстэнд хүч хэрэглэсэн төрийн хуйвалдаан, төрийн эргэлт зэрэг хэлбэрүүдийг ашиглаж төрийн эрхийг хууль бусаар булааж хэмжээгүй эрхт ноёрхлыг тогтоосон улс төрийн нөлөө бүхий бүлэглэлүүдийн ноёрхол мөн. Засаглалын төлөөх тэмцлийн уг зарчим нь авторитаризм төдийгүй тоталитаризмд ч үйлчилдэг. Харин авторитаризмын амьдрах, ноёрхох чадварт тоталитаризмын тодорхой шинжүүд хадгалагдаж байдаг. Тухайлбал, фашист Германд нацист дэглэмийг фурьберггүйгээр, ЗХУ-д большевист дэглэмийг И.В.Сталингүйгээр төсөөлөх боломжгүйн адил франкист Испани ба Салазаровын Португаль зэрэг улс орнуудад авторитарист ба тоталитарист дэглэмийн аль нь тогтсон болохыг нотолж чадаагүй юм. Уг байдлаас үзвээс авторитаризм ба тоталитаризм нь социалист нийгэм дэх улс төрийн дэглэмийн хоёр хэлбэр төдийгүй өөр хоорондоо органик нэгдэл бүхий улс төрийн соёлын загвар мөн.

Тоталитарист дэглэм буюу тоталитаризмд фашист герман-фашист Итали улмаар ЗХУ-д социалист тогтолцоо нурах үе (1990-ээд онд) хүртэл ЗХУ болон зүүн Европт ноёрхож байсан улс төрийн дэглэмийг багтааж байна. Хамрах хүрээний хувьд тоталитаризм нь социалист дэглэмтэй орнууд төдийгүй гуравдагч ертөнцийн орнуудад илүү хамааралтай байв.

Тоталитарист дэглэм нь хувь хүний дотоод ухамсар, үзэл санаа, сэтгэл санаа, дотоод хүсэл эрмэлзэл, чиг зорилго, хөгжлийн аливаа хандлагыг бүхэлд нь нэг үзэл сурталд захируулан нийцүүлсэн хувь хүний төрөлх шинж-дотоод ертөнцийг зохиомлоор өөрчилж нэгдмэл, онцгой

өвөрмөц сэтгэл зүйн хэв шинж бүхий “шинэ” сэтгэлгээний хэв маягийг бий болгодог.

Хувь хүний оюуны ертөнцийг “зохиомол” үзэл суртлаар дамжуулан нийгэм-ангийн бүтцийг өвөрмөц манкуритист маягтай болгодог. Хувь хүний уламжлалт сэтгэлгээний хэв шинжийг өөрчлөх төдийгүй үндэстний уламжлалт, шашин соёл, зан заншил, сэтгэлгээг халж “зохиомол” дэглэмд оруулдаг. Нийгмийн амьдралыг бүхэлд нь нийтлэг байдалд захируулан зохион байгуулсан байдаг.

И.В.Сталины ноёрхлын жилүүдэд Орост (1917-1954) мөн чанартаа цэргийн ба улс төр, үзэл суртлын талаар “онц байдал” тогтож ажлын зарчим нь “уралдаанд гүйгээд” гэх урианд тулгуурлажээ. И.В.Сталин “... бид улс орнуудаас 50-100 жил хоцорсон учраас 10 жилийн дотор гүйцэж түрүүлэх ёстой. Алхах биш гүйх, ямагт яарч гүйх” гэжээ. Дэглэмийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн өвөрмөц компани ажлыг “хэт ба онц яарах” “хатан зориг” гэх мэт уриан дор явуулж тоталитарист үзэл суртлыг хөгжүүлэв.

Энэхүү зохиомлоор үзэл сурталчлагдсан улс төрийн дэглэм нь нийгмийн философи нийгмийн болон улс төрийн ухамсар сэтгэлгээнд улмаар ердийн ухамсрын болон массын улс төрийн соёлын төлөвшилд нөлөөлж нийгмийн дотор зөрчил үүсгэж улс төрийн сөрөг үр дагавруудыг бий болгов.


Л.Геллерийн тэмдэглэснээр “Гүйлт нь яарах, тэвдэх оюун санааг будлиантуулж болж буй үйл явцад үнэлэмж өгөх, эргэж харах, ажлын арга хэрэгсэл зорилгоо дүгнэх боломжийг алдагдуулж гүйж түрүүлэх - яарахын хэмнэл нь бүхнийг зөвтгөсөн албадлагын сэтгэлзүй ноёрхох арга хэрэгсэл болж хүний хувийн хүсэл-ашиг сонирхлыг үгүйсгэв”. Энэхүү тоталитарист ухамсарт тулгуурласан ертөнцийг үзэхүй нь “бодит үнэн байдал”-ыг чимэн хуурамч лоозогносон үзэл суртлыг хийсвэрээр ягштал баримтлагч зохиомлоор бүтээгдсэн үзэл сурталчлагдсан нийгмийн ухамсар төлөвших уг сурвалжийг бий болгож утга учиргүйн (абсурдны) логик сэтгэлгээг төлөвшүүлэв.

Тухайлбал, түүх судлалын салбарт гэхэд л төр ба засгийн удирдагчдын ашиг сонирхолд нийцүүлэн монголын түүх, намын түүхийг өнгөлөн далдалж зохицуулан найруулж бичсэн байна. Түүхийн үнэн мөн чанарыг үзэл сурталжуулж, улс төрийн дэглэмийн ашиг сонирхолд нийцүүлж бичиж байв.

Дж.Оруэллийн хэлснээр “онолын хэлбэршилд орж өнгөлөн далдлагдсан нэр томьёо нь ирээдүйг бус, өнгөрсөн түүхийг бүхэлд нь дэглэмийн үзэл суртлаар дахин бүтээх үүрэгтэй байв”. Тоталитарист дэглэм нь албадлага, хүчирхийлэл, алан хядлагын хэлбэрээр хүний бие организм, оюун сэтгэлд хүчтэй нөлөөлөв.

Догматизмд суурилагдсан нийгмийн ухамсар нь тоталитар дэглэмийн үед фанатализм, буквализм, эсхотологизм зэрэг хэв шинжтэй байдаг.

Дж.Оруэллийнхээр “Аливаа суртал нэвтрүүлэг нь худал хуурмагийг өнгөлөн далдалсан үнэн мэт зүйл байдаг” бол В.И.Ильныхээр аливаа хүчирхийлэл нь худлын илрэл байдаг. Иймд суртал нэвтрүүлэг нь



гэсэн гинжин холбоог үүсгэдэг.

Төрийн тоталитарист үнэлэмж— тоталитарист соёл ноёлох байр суурийг эзэлж буй нөхцөлд фашист алан хядах хэрэгсэл нь өөрчлөгдөж оюун санааных нь хувьд хордуулж улс төр үзэл суртлын хэрэгслээр дамжуулан хүний оюун санааг гэмтээдэг.

Горизанталь тоталитаризм нь үзэгдлийн хүчирхийллийг бий болгож нийгмийн бүх амьд эд эсэд нэвтрэн орж амьдралын хэв маягт нь нөлөөлж улмаар тоталитар дэглэмийн хэв шинж нь нийгмийн амьдралын бүх хүрээнд “хяналт” тогтоож массын сэтгэлзүйд нөлөөлсөн байдаг. Уг дэглэмийн үед албадлагын боол нь итгэл үнэмшилд төөрөлдсөн “үнэмшсэн боол” болох ёстой байв.

Дээрх хэв шинж, тал, байдал нь “түгээмэл” зорилгод хүрэхийн төлөөх (стотальный) нэгдэл юм.

Тоталитар эхлэлийн уг сурвалж нь амьдралд нэвтрэх, үүний тулд үзэл суртлынхаа “үзэл санаа”-г нэвтрүүлж хэл шинжлэлийн түвшинд эргэлтэнд оруулах явдал юм.

Дж.Оруэлл бүтээлдээ “... Шинэ хэл нь

бодит зүйл юм. Шинэ хэл - хэллэг нь нийгмийн ухамсрын онолын түвшинд, ертөнцийг үзэх үзэл ба дадал, зуршлын арга хэрэгсэл төдийгүй оюун санаа, үзэл санаанд нөлөөлж аливаа илэрхийлэх байдлыг төвөгтэй болгодог арга хэрэгсэл юм. Энэ нь социалист реализм мөн. Бодит ертөнцийн мөн чанарыг илэрхий социалист реалист шинжтэй болгосон нь хэт абсурд-шизо маягийн сэтгэлгээгээр ертөнцийг үзэх үзэл баримтлалыг бий болгосон нь $2 \times 2 = 5$ гэсэнтэй адил юм” гэжээ.

Сэтгэлгээний тоталитарист хэв шинжит байдал нь хүний амьдрах үйл ажиллагаа ба зан байдалд хоёрдмол шинжтэй хэм хэмжээг бий болгодог. Энэ утгаараа хувь хүн хоёрдмол шинж бүхий үзэл баримтлалтай байдаг.

Үзэл суртлаар дамжуулан дарангуйллаа хэрэгжүүлсэн нийгмийн төр ба намын улс төрийн шийдвэрүүд нь “имунитет” халдашгүй шинэ үг хэллэгийг нийгмийн амьдралд хэвшүүлдэг. Тухайлбал, халуун дотно, нийтээр зөвшөөрөгдсөн, санал нэгтэйгээр, төр нам засгийнхаа ачаар, сайшаан дэмжигдсэн, төрийн ноён нуруутай хүн гэх мэт үг хэллэгээр дамжуулан хэрэгжүүлсэн байна. Энэ зохиомол арга хэрэгсэл нь масст хоёрдмол санааг төрүүлж, оюуны гэмт хэрэг гэх үзэгдэл үүссэн. Санаа - сэтгэл, оюун санааны гэмт хэрэг гэгч үйлдэгдэх нь мөн чанартаа тоталитаризм “цэвэр” сонгодог хэлбэрээрээ оршин буйн шинж төдийгүй оршихуйн төгсгөлийнх нь эхлэл юм.

Конформизм ялж, иргэд бүхэлдээ массын шинжийг олсон нь Ратенаугийн хэлснээр “нийгэмд нэвтэрсэн зэрлэгүүдийн дайралтын илрэл” юм. Төр нам засгаараа байнга шаргуу, гүнээ энэрэл халамжит байдлаар удирдуулах нь хүнийг эцсийн дүндээ өөрийн бие даасан байдлаа алдах, хариуцлагаас бултах, улмаар бодгалийнхаа давтагдашгүй мөн чанарыг алдахад хүргэдэг. Үүний үр дагаварт үл итгэсэн, егөөдсөн, хардаж сэрдсэн хандлагаар хандах, хөндий хүйтэн - хүйтнээр үзэх, бие биенээсээ хүнийсэх шинжид автан шаналсан хувь хүн төлөвшдөг.

Тоталитаризмд бүрэн автсан хүний улс төрийн соёлынх нь илрэл ертөнцийн бодит байдлыг үл ойлгосон, шүүмжлэл - өөрийн шүүмжлэлд эмзэглэсэн бэртэгчин зан байдалтай, нийгэмд эзлэх бие даасан байр сууриа хадгалах хандлага хүсэл сонирхол, чадваргүй болсон байдаг.

Ийм учраас тоталитарист ухамсрын хувьд хэт схемчлэгдсэн, редакторлагдсан, нийгмийн амьдралыг хэт хялбарчилсан шинжүүд нь төр, намаас хүлээн зөвшөөрөгдсөн бүхнийг цорын ганц “зөв” үзэл санаа болох “үнэн” гэдэгт захируулж нийгмийг бүхэлд нь үзэл сурталжуулдаг. Энэ “үнэн” “ганц зөв үзэл”-ийг хадгалж хамгаалахын тулд тоталитар ухамсрыг урьдаас төлөвлөсөн үндэслэлтэй, төгс боловсронгуйд итгүүлэн үнэмшүүлсэн улс төрийн (миссианство) ёслол төгөлдөр байдлыг хэвшүүлдэг байна. Уг хэвшмэл байдлыг тогтооход нам – төрийн аппарат үйлчилдэг. Ингэснээр шинжлэх ухаан, урлаг, соёл, философи, эдийн засаг, улс төр, ёс суртахуун нь “цорын ганц – үнэн зөв” түлхүүр үзэл санаанд нийцсэн байх ёстой болж эдийн засаг, улс төр, шинжлэх ухааны нийлмэл, нэгдмэл төр, намаас халамжлагдсан бүтэц үүсдэг. Уг дэглэм тогтох уг сурвалж нь Сталинчлагдаж, Гитлержсэн “Марксист үзэл суртал” байв.

Ертөнцийг үзэхүйн үндсэн мөн чанар нь ертөнцийн юмс үзэгдлийг тайлбарлахдаа “туйлын худлын эсрэг туйлын үнэн”, “муу хорлолын эсрэг сайн зүйл”, “харанхуйн эсрэг гэрэл гэгээ” зэрэг томьёолоор тайлбарладаг нэгэн хэмнэл бүхий хандлага боловсрогдсон байна. Төвийн ба дундаж гэсэн томьёолол утсан байна.

Иргэдийн ухамсарт хүний талаарх ангилал, ялгаварлан гадуурхах үзэл ноёрхож дайсны дүр төрх, харийн хүн, хүний хүн, дутуу төлөвшсөн - хүмүүжсэн хүний төрх, жинхэнэ хүн биш гэх ойлголт төлөвшиж, хүнийг алах зэрэг үйлдлүүд боловсрогдсон аж. Хувь хүний нийгэмд эзлэх байр суурь нийгэм улс төрийн болон бусад тулгамдсан асуудлуудыг нэгдмэл ойлголт болгосон хандлага нь сайн ба муу зүйлийг хэт заагласан бурхан ба чөтгөрийн түвшинд ертөнцийг хувааж эрсдэл хийсэн байна. Энэ нь загалмайтны аян ба манихиский-массионизмын үзэл баримтлал болон хувирч хэтрүүлэн хэт нэг талыг барьж туйлшрах байдалд хүргэсэн. Энэ туйлшрал нь хэрэгжүүлэх зорилго ба боломжтой байдлын хооронд зөрчлийг үүсгэж тоталитарист үзэл сурталчид ертөнцийг хар, цагаанаар хуваан үзэж ёс суртахууны туйлшралд хүргэсэн хандлага үйлчилсэн ба бүх асуудалд яаралтай-хэт яаралтай нэг дор эгшинд эцсийн шийдвэрийг шаарддаг зэрэг хэмнэлд хэвшүүлсэн байна.

Иргэдийг дэглэмтэй харьцаж буй байдлаар нь (2) ангилж дэглэмтэй санал нийлсэн хэсгийг сайн сайхны хүч хэмээж, санал нийлж

чадахгүй хэсгийг нь чөтгөрийн хүч гэж хуваасан байна. Бидэнтэй хамт л бус бол бидний эсрэг хүч гэх үзэл ноёрхсон.

Улайран итгэгч – (панатик) зарчмын хувьд бол аливааг үл зөвшөөрсөн, эсвэл эсэргүүцсэн хүн нь чөтгөрийн хүчний төлөөлөгч хэмээн тооцогддог. “Хуйвалдаан” гэх үзэл нь түүх, нийгмийн болон улс төрийн хүчин зүйлсийг бодитойгоор үнэлэх боломжийг устгадаг. Дундыг баримтлахыг үгүйсгэдэг ба буулт хийх тухай ойлголт байсангүй.

Улс төрийн бодлого - үзэл суртлын зорилгыг үл зөвшөөрсөн болон удирдагчдын эсрэг хандлагатай хүмүүсийг хүлээн зөвшөөрөх нь “хуйвалдаан”-д оролцогчидтой нэгдэж байна гэсэн ойлголтыг төрүүлж ангийн “дайсан”-ыг илрүүлэх хэлбэрт шилжиж хавчиж, хардаж сэрдэж байв.

Америкийн түүхч Р.Хофстедтерийнхээр “... хуйвалдаан нь хэтэрхий хөөргөн, дэврүүлсэн, хардаж сэрдсэн, уран сэтгэмжийг илэрхийлсэн хэв маяг” байсан юм. Энэхүү паранеодный хэв маягийн ялгагдах онцлог шинж нь энэ маягийг баримтлагчид нь түүхийн явц дахь хөдөлгөгч хүч болсон үйл явцыг хамарсан “хуйвалдаан” өргөн хүрээг хамарч байв.

Боловсролын тогтолцоог өөрсдийн гарт төвлөрүүлж хязгааргүй эх сурвалжуудад тулгуурлан “тархи угаах”-д чиглэсэн зохион байгуулалттай бодлого явуулж “хардах – сэрдэх-үзэн ядах” үзлийг ертөнцийг үзэх үзлийн хэмжээнд тавьсан нь ухамсрын нэгэн төрөл зүйл мөн.

Нийгмийн гишүүд улс төр, шашны зэрэг үйл ажиллагаанд оролцохдоо ихэвчлэн хэт туйлширсан экстермист хандлагатай байдаг. Үүний үр дагавар нь посткоммунист орнуудын нийгмийн амьдрал нь фантастик, сюрреалист шинжтэй болсон юм.

Массын олонход бодит байдал нь дайсан - тагнуул, эсэргүү - урвагчид, хуйвалдагчид, санаатайгаар үйлдэгчид, хор хөнөөлтнүүд болж хувирсан. Дэлхий ертөнцийг хүртэл (2) лагерь болгон хуваасан байна.

Тоталитар төрийн хүчирхэг үзэл суртал ноёрхож тоталитарист ухамсартай хүнийг төлөвшүүлж, тэдний ертөнцийг үзэх үзлийг “гажиг” хэв шинж бүхий холимог зүйл болгож рекордыг бурханчлан шүтэх, хувьсгалт баатарлагийг дээдлэн хүндэтгэх, сохроор итгэх, хэт хянамгай байх, өөрийгөө хэт үнэлэх, аливаад

ичгүүргүй хандаж уралдан түрүүлэх гэх мэт шинж хандлагаар өөрчилж эрх мэдлийн бүх түвшинд удирдагчтай байх - вождизм ноёрхож хүнийг үйлдвэрлэх хүчний нэг элемент гэж үзэв.

Гэгээрэхүй, боловсрохуйн бодит шинж, мөн чанарыг үзэгдэх байдлаар сольж соёл, урлаг, уран бүтээлийг хийсвэрлэсэн байна.

Мөн “гаж” буруу хослолын зэрэгцээгээр конформизм “дундаж байдал”-д сэтгэл ханамжтай байх зэрэг нь бүхэлдээ массын нийгэм улс төрийн хэв шинжийг “дунд” түвшинд буюу “матрица” байх шинж байдлыг тодорхойлсон нөхцөл, үндсийг нийгмээс бүрдүүлсэн байна.

Масс гэдэг нь хүмүүсийн өвөрмөц нэгдэл юм. Х.Ортега Гассетын тэмдэглэснээр бол масс нь эгэл хүмүүсийн олонх бөгөөд дундач - эгэл шинж байдал юм. Нийгмийн зүгээс хүнийг үзэх нацизм буюу нэгэн төрлийн өөрөө өөртөө хайртай байх, нийгэм ба хүмүүсийг бүхэлд нь нүгэлгүй гэж үзэх үзэл хандлага үйлчилдэг. Ийнхүү өөрөө өөрийгөө хуурах, өөрийнхөө болон өөрийнхөө хүрээллийн тухай, өөрийн ахуй нөхцөл- боломж, шинж байдлын талаарх “үнэн”-ийг мэдэх боломжгүй ба мэдэх сэдэл төрдөггүй байна.

“Үнэн”-ээс байнга зугтаж, хийрхсэн хоосон бодол, гадаад үзэгдэл юмст автагдаж, амьдралыг зөвтгөж “аз жаргал”-ыг хийсвэрлэсэн сэтгэлзүй үйлчилдэг.

“Элит” нь өндөр дээд оюуны чадвартай боловч ердийн хүний ухамсрын түвшинд амьдарч болох ба хувь хүн өөрийн амьдралын хэм хэмжээг нийгмийн буянт үйлстэй холбон үздэг. Хувь хүн үзэл сурталд захирагдсан сахилга батыг сахидаг. Өөртөө нийгмийн эрх ашигт зохицсон шаардлага тавьж хариуцлага хүлээн хохирч байдаг.

Тоталитар тогтолцоо нь засаглалын ба нэр хүндийн оргил хүртэлх ёслол төгөлдөр дундаж байдалд хүрэх нөхцөлийг бүрдүүлдэг. Массын дундаж байдлын илрэл нь төр нийгмээс тогтоосон дэг журмыг баримтлан нэр төр, албан тушаалд зүтгэх, албан тушаалыг шүтэх, хэргэм зэрэг албан тушаалд шунахайрах бөгөөд энэ нь тоталитар ухамсрын интеграл - доминант буюу ноёлох шинж болсон.

Адилтгах үйл явц нь конформизмыг бэхжүүлэх ба юмс үзэгдлийг нэг өнцгөөс харах нь өөртөө итгэлгүй, өөрийн үнэлэмжийг хамгаалах механизмгүй учраас тодорхой зорилго чиглэлтэй, сэтгэлзүйн дарамтад өртдөг. Хувь хүн

өөрийгөө өөрөөсөө илүү хүчтэй, нэр хүндтэй хүмүүстэй адил түвшинд авч үзэх нь хүнийг өөртөө итгэлтэй болгодог. Өөрийнхөө угсаа гарал, нийгэмд эзлэх байр сууриа олж чадаагүй хүмүүс өөртөө итгэлгүй байдаг учраас хүнийг дагуулах чадвар муутай, удирдлагын амыг харах, хүний даалгавар, зааврыг биелүүлэхдээ идэвх зүтгэлтэй, хөөрүү бөгөөд цовоо шаламгай ханддаг бөгөөд ёс зүйн болон гоозүйн түвшинд анхааралгүй ханддаг нь нийгмийн золиос болох уг үндэс нь байдаг. Дундаж боловсролтой байдал тоталитар дэглэмийн үр дүн мөн. Амьдралын дунд зэргийн түвшин нь тоталитар дэглэм унахад илт мэдрэгдэж амьдралын үхээнц хэв маяг илэрч тоталитаризмын ноёрхол нь бүхэлдээ цөвүүн цагийн нэгэн төрөл бөгөөд нийгмийн бүх хүрээнд сөрөг үр дагавруудыг үлдээсэн байна.

ДҮГНЭЛТ

Тоталитаризмын дээрх ойлголтуудыг сонгодог үзэл санаа, хэв маягийн агуулгаар нь ойлгох хэрэгтэй. Бодит амьдрал дээр юмсын нөхцөл байдал нь илүү төвөгтэй, ээдрээтэй байдаг. Хор уршигт зүйл нь ямар ч өнгө зүстэй байсан ч хүний бурхнаас заяасан төрхийг үгүйсгэж, түүний эрх чөлөөг хүсэмжлэх хүсэл тэмүүллийг устгаж, хувь хүний дотоод ертөнцийнх нь мөн чанарын уг сурвалжийг арилгахгүй тул тоталитарист дэглэмийн оргил үед ч бүх нийтийн ухамсарт бүрэн хэмжээгээр нөлөөлсөн гэсэн дүгнэлт хийж болохгүй юм. Энэ утгаараа тоталитаризм нь нийгмийн бодит байдлыг зориудаар үзэл сурталжуулсан сэтгэлгээний гажуудсан тусгал юм.

Тоталитарист дэглэмийн үед нийгэмд ертөнцийг ойлгох зөв ойлголт, үзэл санаа байсан учраас гажуудсан үзэл суртлаас нийгмийг ангижруулах үндэстний болон хувь хүний оюуны чадамж нь хадгалагдан үлдсэн нь ардчилсан үзэл санааг хүлээн авах, үндэстний оюуны соёл- ухамсраа сэргээх нөхцөл нь болж байсан нь 1990-ээд онд монголд нийгмийн өөрчлөлт шинэчлэл хийх боломж болсон юм. Үүний үндсэн дээр 1992 онд шинэ үндсэн хууль батлагдаж нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж нийгэм, улс төр эдийн засаг, оюун санааны амьдрал үндсээрээ өөрчлөгдөж хүнлэг, энэрэнгүй иргэний ардчилсан нийгэмд шилжсэн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Баталов, Э. (1999). Политическая культура современного Американского общества. Москва
- Бирюков Н. Сергеев В. (1995). “Парламентская деятельность и политическая культура” общественные науки и современность. М., №02
- Владикова Ю. (1991). “Культура и политическая культура” Философия в современном мире. Москва
- Монголын сэхээтний улс төрийн ухамсар соёлын төлөвшлийн зарим асуудал (1993), (багш сэхээтний жишээн дээр) Улаанбаатар
- Улс төрийн шинжлэх ухаан. (1996). Улаанбаатар
- Улс төрийн философи. (2007). Улаанбаатар
- Харьцуулсан улс төр судлал. (2006)., Улаанбаатар
- J.Wolff. (1992). Introduction to Political Philosophy. L.,
- Leo Strauss. (1992). Introduction to Political Philosophy. L.,
- Lian. Hampsher. A history of modern Political Thought.
- Micheal Lessnof. Political Philosophers of the XX century.